



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/547

Булган сум

### Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалт, Засгийн газрын 2024 оны “худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын хүрээнд “Анхдагч хаалга” сэргээн засварлах ажлын гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, 5,000,000 (таван сая) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д олгосугай.

2.Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д үүрэг болгосугай.

3.Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр), Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д тус тус үүрэг болгосугай.

4.Дээрх зардлыг Булган аймаг, Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2024 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгагдсан аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



6324010878